

БАТЛАВ. БОЛОВСРОЛЫН САЙД

П.НАРАНБАЯР

УДИРДАМЖ

“Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад 2025-2026 оны хичээлийн жилээс суралцах суралцагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай”

2025.06.10

Дугаар 01

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусlamж олгох, дэмжлэг үзүүлэх, эргэн төлүүлэх журам (цаашид “журам” гэх)-ын дагуу Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн A/271 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр дэлхийн шилдэг их сургуулийн магистр, докторын хөтөлбөрт суралцах суралцагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад оршино.

1.2. Ажлын хэсгийн гишүүд сонгон шалгаруулалтын ажилд идэвхтэй, шударга, ил тод байх зарчмыг баримтлан ажиллана.

Хоёр. Сонгон шалгаруулах үе шат, хугацаа

2.1. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа дууссаны дараа Ажлын хэсгийн гишүүдэд Боловсролын зээлийн сангийн шалгаруулалтын цахим системд нэвтрэх эрх нээх бөгөөд сонгон шалгаруулалтыг 2 үе шаттайгаар 15 өдрийн дотор хийж гүйцэтгэнэ.

2.2. Сонгон шалгаруулалт эхний шатанд scholarship.elf.gov.mn цахим хаягаар тэтгэлгээр суралцах хүсэлт гаргагчийн ирүүлсэн материал шалгуур, шаардлага хангасан эсэхийг дараах байдлаар хянаж баталгаажуулах ажиллагаа хийгдэнэ:

2.2.1. оролцогчийн ирүүлсэн баримт бичгийн бүрдэл хангагдсан, үнэн зөв эсэхийг нягтлах;

2.2.2. журмын 2.2.2, 5.3.2-т заасан шаардлагыг Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт дахь тэргүүлэх мэргэжлээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцах урилга авсан эсэхийг шалгаруулалтад оролцогчийн системд оруулсан нэвтрэх нэр, нууц үгээр сургуулийн цахим хуудсаар орж баталгаажуулах;

2.2.3. журмын 2.2.1, 2.2.3, 2.2.4, 2.2.5, 2.2.6, 5.6.1-д заасан шаардлагыг хангасан эсэхийг ирүүлсэн материал, Боловсролын зээлийн сангийн мэдээллийн санг ашиглан баталгаажуулах;

2.2.4. журмын 10.4.2-т заасан шаардлагыг элссэн сургуулийн эрэмбэ, урилгад бичигдсэн мэргэжлийн чиглэлийг баталгаажуулах;

2.3. Сонгон шалгаруулалтын 2 дугаар үе шатанд Ажлын хэсгийн гишүүд сонгон шалгаруулалтад оролцогчийн баримт бичигт үндэслэн 100 хүртэл оноогоор, энэхүү удирдамжийн 3.1-д заасны дагуу үнэлж нэгдсэн дүнг гаргана.

Гурав. Оноогоор үнэлэх аргачлал

3.1. Ажлын хэсгийн гишүүд сонгон шалгаруулалтад оролцогчийн баримт бичигт журмын 3.10 дахь заалтыг үндэслэн дараах аргачлалын дагуу оноогоор үнэлнэ.

3.1.1. Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Таймс Хайэр Эдүкейшн Вөрлд Юниверсити Ранкингс"-аас цаг хугацааны хувьд хамгийн суулд тогтоосон эрэмбийн жагсаалтыг үндэслэн 25 хүртэл оноо өгөх. Үүнд: жагсаалтын эхний байранд сургуульд 25 оноо, харин 100 дугаарт жагссан сургуульд 0.25 оноогоор үнэлгээ өгөх буюу онооны тооцооллыг нэг байр тутамд 0.25 оноогоор буурах ижил интервалаар хийнэ;

3.1.2. Оролцогчийн суралцах сургалтын байгууллагаас олгосон тэтгэлгийн хэмжээг суралцагчийн нийт сургалтын төлбөрт харьцуулсан хувийн жинг үндэслэн 40 хүртэл оноо өгөх. Сургалтын байгууллагын тэтгэлгийн дээд хэмжээ 99 хувь байхаар тооцон ижил интервалаар буюу хувь тутамд 0,4 оноогоор бууруулж үнэлэх;

3.1.3. Оролцогчийн суралцах сургалтын байгууллагын сургалтын төлбөрийн хэмжээнээс хамаарч 35 хүртэл оноогоор үнэлгээ өгөх. 2025 оны сонгон шалгаруулалтад оролцсон оролцогчдын нэг жилийн сургалтын төлбөрийн хамгийн бага, их хэмжээг тодорхойлон, сургалтын төлбөрийн хамгийн бага дунд 35 оноо, өндөр дунд 1 оноог өгч, ижил 0.25 онооны интервалаар үнэлэх;

Дөрөв. Оноогоор эрэмбэлэх

4.1. Сонгон шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн материалд суурилсан үнэлгээг оноогоор жагсааж, оролцогчийн оноо тэнцсэн тохиолдолд журмын 3.11-д заасны дагуу эрэмбэлж, дахин тэнцсэн тохиолдолд мэргэжлийн чиглэлийн эрэмбийг баримтална.

Тав. Ажлын хэсгийн хурлын дэг

5.1. Ажлын хэсэг нь дарга, 10 гишүүн, 2 нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд 11 гишүүн үнэлгээ өгч, шийдвэр гаргаж, нарийн бичгийн дарга үнэлгээ хийх ажиллагаанд оролцохгүй.

5.2. Нарийн бичгийн дарга Ажлын хэсгийн хурлын бэлтгэл хангах, ирц бүрдүүлэх, хурлыг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, Ажлын хэсгийн тайлан боловсруулж баталгаажуулах болон сонгон шалгаруулалтад оролцогчдод Ажлын хэсгийн шийдвэрийг танилцуулах, сонгон шалгаруулалтын материалиар архивын нэгж бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.3.Ажлын хэсгийн гишүүдийн ирц 75 хувь буюу түүнээс дээш тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцож, хуралд ирсэн гишүүдийн олонхийн саналаар буюу 50+1 хувийн саналаар шийдвэр гаргана. Ажлын хэсгийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас урьдчилан мэдэгдэж, даргын зөвшөөрлөөр онлайн оролцож болох бөгөөд онлайн ажиллах гишүүний тоо нэгээс хэтрэхгүй байна.

5.4.Ажлын хэсэг гишүүдийн үнэлгээний нэгдсэн дүнг хэлэлцэн батална.

5.5.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын хяналтын тоонд багтсан болон багтаагүй оролцогчдын нэrsийг онооны дүнгээр эрэмбэлэн жагсаалт гаргаж, сонгон шалгаруулалтын дүн, тайланг Боловсролын сайдад хүргүүлж, шалгаруулалтад тэнцсэн иргэдийн нэрийг сайдын шийдвэрээр баталгаажуулна.

5.6.Нарийн бичгийн дарга нар сонгон шалгаруулалтын хяналтын тоонд багтсан эсэх талаар оролцогчдод цахим шуудангаар мэдээлэл хүргэнэ.

5.7.Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн хуурамч баримт бичиг бүрдүүлсэн болох нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд журмын 10.11-д заасны дагуу зээл олгохоос татгалзана. Зээл олгохоос татгалзсан тохиолдолд 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор онооны дүнгээр жагсаалтын дараагийн дугаарт эрэмбэлэгдсэн оролцогчийг шалгаруулж, шийдвэрлүүлнэ.

5.8.Оролцогч сонгон шалгаруулалтын дүнг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд журмын 3.14-т заасны дагуу сангийн дэргэдэх Орон тооны бус зөвлөлд гомдол гаргаж болно.

5.9.Сонгон шалгаруулалтын ажиллагаа дууссаны дараа Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгийг сонгон шалгаруулалтын дүн, тайлан, холбогдох материалын хамт Боловсролын яам болон Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны даргад хүлээлгэн өгнө.

-оОо-